

**Монголчуудын идээ ундааны соёлд холбогдох оньсогын
уран дүрслэлийн онцлог**

Чулууны ЗАЯАСҮРЭН*

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Аман зохиол судлалын салбар

Received: Jun 10, 2024

Revised: Jul 16, 2024

Accepted: Aug. 18, 2024

Хураангуй: Энэхүү өгүүлэлд монголчуудын соёлын нэгэн хэсэг болсон таван тансаг идээ ундаагаар бүтсэн оньсогын уран дүрслэлийн онцлогийг тодруулав. Монголчуудын идээн ундааны соёлын онцлогийг таньж мэдсэн арга, туршилага нь монгол ардын оньсогын дүрслэлд тусгалаа олжээ. Үүнийгээ үгийн урлагаар дамжуулан үр хүүхдэдээ заан сургаж, ахуй амьдралд бэлтгэж үлгэрлэн сургаж иржээ. Энэ чиглэлийн оньсогод таван хошуу мал, түүний эд эрхтэнтэй адилтаж, амьдчилан дүрсэлсэн нь малчин хүний үйл ажиллагаа, ёс заншил сэтгэлгээний илрэл болж байгааг жишээгээр харуулсан болно.

Түлхүүр үг: цагаан идээ, бор идээ, шар идээ, ногоон идээ, улаан идээ, адилтгал, зүйрлэл, хүншүүлэл, амьдчилал, дүр дүрслэл

**The characteristics of riddle related to the
food culture of the Mongols**

ZAYASUREN Chuluun

Department of the Folklore studies, Institute of Language and
Literature, Mongolian Academy of Sciences, Mongolia

Abstract: This article highlights the unique artistic imagery found in riddles based on the five exquisite traditional foods and beverages that are an integral part of Mongolian culture. The knowledge and experience gained from understanding the distinctive aspects of Mongolian food culture are reflected in the depiction of folk riddles.

* © Ч.Заяасүрэн

Email: zayasurench@mas.ac.mn

Through the art of words, Mongolians have passed this knowledge down to their children, teaching and preparing them for everyday life. In this type of riddle, the five types of livestock and their body parts are metaphorically represented and vividly illustrated, reflecting the activities, customs, and mindset of herders.

Examples demonstrate how these riddles serve as an expression of nomadic life. Word-based arts, including riddles, are a classic example of Mongolian folk wisdom. They preserve and transmit practical knowledge about daily life and livestock identification across generations, ensuring that future generations understand and embrace their cultural heritage.

Key words: Mongolian culture, knowledge, riddle, heritage, future

Удиртгал

Бидний өвөг дээдэс өдөр тутмын амьдрал ахуйгаас олж авсан мэдлэг туршлага, хийж бүтээснээрээ аман яруу найргийн (үлгэр, зүйр цэцэн үг, ерөөл, магтаал, тоглоом наадгайн үг хэллэг, тоглоом, оньсого, таавар, ертөнцийн гурав) олон төрлийг зохиож, тал бүрийн авьяас чадвар, оюун ухаан, сэтгэлгээгээ хөгжүүлэхийн зэрэгцээ тэмдэглэлт баяр наадам, өдөр тутмынхаа аж амьдралдаа өргөн хэрэглэж, үр хүүхдээ ахуй амьдралд үлгэрлэн дагуулж, сурган хүмүүжүүлж, хойч үедээ өвлүүлж ирсэн билээ.

“Монголчууд өөрийн бие цогцос, эд эрхтнээс эхлээд хувцас хунар, орон гэр, хөдөлмөрийн багаж зэвсэг, ажил үйлс, таван хошуу мал, байгаль ертөнц болон идээ ундаагаа хүртэл оньсоголож ирсэн” (ТО, 1966: 6) байдаг. Эдгээрээс идээ ундааны соёлд холбогдох оньсогын дүр дүрслэл нь бидний оршин амьдрахын олон талыг илэрхийлдэг учраас сонирхолтой судлагдахуун юм.

Монголчуудын идээ ундаа бол ёс заншил, өв соёл, хүндэтгэлийн бүхий л цогцыг агуулж байдаг. “Цагаан идээ гэдэг нь өрөм сүү, тараг, ааруул, хурууд зэргийг, хар идээ гэдэг нь архи, ус хоёрыг, улаан идээ хэмээн мах шүүсний зүйлийг, шар идээ гэдэг нь шар тосны төрлийг, хөх (ногоон) идээ гэдэгт сонгино, саримс, гогод, мангир зэргийг хэлдэг” (Дулам, 1992: 36) бөгөөд эдгээрийг таван өнгөөр илэрхийлэн *таван тамсаг идээ* хэмээн нэрлэдэг.

Монгол оньсогын чиглэлээр судалгаа хийж ирсэн өмнөх үеийн судлаачдын нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний болон сурталчилгааны өгүүллийн агуулгыг нягтлан үзэхэд идээ ундааны соёлд хамаарах оньсогын уран дүрслэлийн онцлогийг тусгайлан авч үзсэн судалгааны өгүүлэл эдүгээ гараагүй байна.

Идээ ундааны соёлд хамаарах оньсогын уран дүрслэлийг онцлогийг “Түмэн оньсого”-I, II боть (1966/1989), “Монгол ардын оньсого” (1983), “Монгол ардын оньсого таавар” (1990) болон бусад холбогдох ном эмхэтгэлд орсон оньсогоос тодруулж, өөрийн дүгнэлтээ дэвшүүлсэн болно.

Судалгааны арга зүй

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд өмнөх эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүн, тухайн сэдэвт холбогдох ном, сурах бичиг болон бусад холбогдох эх хэрэглэгдэхүүнийг үзэж, Монголчуудын *соёлын нэгэн хэсэг болсон таван тамсаг идээ ундааны сэдвээр бүтсэн оньсогын уран дүрслэлийн онцлогийг тодруулахдаа нүүдэлч малчдын өдөр тутмын аж амьдрал, таван хошуу малтай нь холбож, анализ хийх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг* ашиглав.

Таван тамсаг идээ

Цагаан идээ: Монголчууд эрт дээр үеэс таван хошуу малынхаа сүүг “идээний дээд” хэмээн эрхэмлэн хүндэтгэж дээдэлж ирсэн. Тэд малынхаа сүүг төрөл бүрийн аргаар боловсруулан ааруул, бяслаг, өрөм, тараг, аарц, эзгий, цагаан тос, шар тос, айраг, ээдэм зэргийг бэлтгэж, өдөр тутмынхаа хоол хүнсэндээ өргөн хэрэглэдэг. Эдгээр цагаан идээнийхээ онцлог тус бүрийг ахуй амьдралынхаа явцад таньж мэдсэнээ монгол хүний танин мэдэх сэтгэлгээний илэрхийлэл болсон оньсогодоо оньсоголсон нь цөөнгүй тохиолдож байгааг тодруулъя.

Дээр нь бэржгэр цагаан

Дунд нь зөөхий цагаан

Доор нь азай цагаан /өрөм, сүү, хусам /, (ТО, боть-II, 1959: 117)

гэсэн оньсогод хөөрүүлж байгаа сүү нь өрөм, сүү, хусам гэсэн гурван давхар үелсэн тогтоцтой болдгийг дүрсэлжээ. Энд өрмийг бэржгэр цагаан, сүүг зөөхий цагаан, хусмыг азай цагаан гэж өвөрмөц онцлог шинж байдлаар нь дүрсэлжээ.

“Оньсого нь дүрслэх аргын хувьд нэн баялаг бөгөөд эдгээрээс хагас зүйрлэлийн арга, шинж байдлыг тоочин дүрслэх гэсэн хоёр арга голлодог гэж судлагчид үзжээ. Хагас зүйрлэлийн аргаар дүрслэхдээ уг юмны шинж тэмдгийг хэвээр дүрслэн, нэрийг нь өөр зүйлээр сольж далдуур зүйрлэсэн байдаг бол шинж байдлыг тоочин дүрслэхдээ уг нэрийг хэлэлгүйгээр гол шинж тэмдэг, төрх төлөвийг тоочин бичсэн байна” (Сампилдэндэв, 2015: 150). Энэ нь бүх оньсогод хамааралтай биш, зөвхөн ижил төстэй зүйлтэй адилтгасан бүтэцтэй оньсогод хамааралтай юм. Жишээлбэл:

Эрдэнийн цагаан нуур

Эрхэм шар нөмрөгтэй /сүү, өрөм/, (ТО, боть-II, 1959: 117)

гэсэн оньсогод сүү, өрөм хоёрыг чухал хэрэгцээт чанараар нь эрдэнэ, эрхэм дээд хэмээн жишин харьцуулжээ. Ингэхдээ эрдэнэ мэт хүний ахуй амьдралд чухал хэрэгтэй сүүг их багын хэмжээгээр нь нуур далайтай адил мэтээр ихэсгэн дүрсэлсэн бол тогоотой сүүний дээгүүр тогтсон өрмийн өнгийг нөмрөгтэй тун төстэй байгааг хүний ой тойнд буухаар дүрсэлжээ. Мөн:

Их нуурын амт сайхан

Их газрын зэрэглээ сайхан /гүүний айраг, айргийн амт/,

(ТО, боть-I, 1966: 143)

хэмээх оньсогод айргийн их багын хэмжээг нууртай жишин адилтгасан бол удаах мөрд айргийн амтны сайхныг байгалийн үзэгдэл болох зэрэглээтэй адилтгажээ. Энэ чиглэлийн оньсогод монголчуудын аливаа зүйлийг гярхай ажигладаг онцлог шинжийг нь урнаар дүрсэлжээ. Оньсогын дүрслэлд “таалгаж буй юмныхаа онцлогийг товойлгож тодруулахын тулд тодотгогч тодотгуулагчийн харьцаатай нэрийн холбоогоор адилтгадаг” (Ганцэцэг, 2015: 30) онцлог байна.

Идээ ундааны соёлд холбогдох оньсогод зүйрлэлийн аргыг ашигласан жишээ ч цөөнгүй байна. Жишээлбэл:

Шингэн байтлаа ус шиг

Цагаан байтлаа цас шиг/сүү/, (ТО, боть-I, 1966: 142)

гэх буюу эсвэл

Ус мэт шингэн

Чихэр мэт амттан /сүү/, (МАОТ, 1990: 164)

гэж сүү бол ус шиг шингэн ч цас мэт цагаан өнгөтэй, амт нь чихэр мэт хэмээн тус бүр адилтган зүйрлэжээ. Дээрх оньсогын дүрслэлээс харахад хүмүүс ахуй амьдралынхаа явцаас ажиглаж олж мэдсэнээ ямар нэгэн төстэй зүйлтэй жишин харьцуулах замаар гол онцлог шинжийг тодруулдаг нь тэдний үндсэн арга ажээ. Энэ нь нэг талаас танин мэдэх үйл ажиллагааны гол арга хийгээд сэтгэхүйн үйл юм.

Жий гэдэг голд

Ус тогтсоныг үзлээ

Жарантай цагаан нуурт

Шувуу суусныг үзлээ /айраг, хөхүүр, бүлүүр/,

(ТО, боть-I, 1966: 142),

гэсэн 4 мөрт оньсогод айргийг устай, хөхүүрийг нууртай, бүлүүрийг шувуу болгон амьшуулах замаар тухайн дүрслэгдэхүүнийхээ шинж байдлаар нь адилтгахдаа хэтрүүллийн аргыг ашигласан байна.

Амьдын шүүс

Үхсэний хальс

Ургамлын гол

Ундааны дээж /гүүний сүү, хөхүүр, бүлүүр, айраг/, (ТО, боть-II, 1959: 117)

хэмээх оньсого 4 мөр шүлгээс бүрдсэн боловч мөр бүр нь тодорхой нэг зүйлийг дүрсэлжээ. Эхний мөрд гүүний (саам) сүүг амьд малын идээ шүүстэй, хоёр дахь мөрд айргийн хөхүүрийг үхсэний хальс гэж онцлог шинжээр нь тухайн эд зүйлээ утга далдлан дүрсэлжээ. Оньсогын гурав дахь мөрд айргийн бүлүүрийг ургамлын голтой адилтгажээ. Тухайн оньсогын агуулгад айргийг боловсруулахад шаардагдах эд зүйлс бүрийн онцлог шинжийг тойруу замаар утга шилжүүлэн сонирхолтой байдлаар дүрсэлжээ.

Монголчууд цайг өдөр тутмын ахуйн хэрэглээндээ хэрэглэхээс гадна өглөө болгон айл гэрийн эзэгтэй цайныхаа дээжийг нарандаа өргөх, орой саалийнхаа дээжийг долоон бурхандаа өргөх, бэр буулгах ёслол болон хүүхдийн угаалгын

зан үйл гэх зэрэгт өргөн хэрэглэж ирсэн соёлтой ард түмэн. Энэ утгаараа цайны соёлд холбогдох цөөнгүй оньсого зохиосон байдаг. Жишээлбэл,

Дээрээс ирсэн дэвхэн товхон

Доороос ирсэн элбэг хар

Өнгийг нь засдаг өл буурал

Амтыг нь засдаг амраг цагаан

Тавыг нь хангадаг тарган шар /цай, ус, сүү, давс, тос /, (ТО, боть-II, 1959: 118)

гэсэн оньсого 5 мөр шүлгээс бүтсэн бөгөөд мөр бүрд нь эд юмсын онцлог шинжийг тодорхой тоочин дүрсэлжээ. Эхний мөрд цайг “дээрээс ирсэн дэвхэн товхон” гэсэн нь хаа газраас гаралтайг хэлэхийн хамт шинж байдлыг илэрхийлжээ. Удаах мөрд “доороос ирсэн элбэг хар” гэсэнд ус нь газрын гүнээс ундрган гардаг, “Өнгийг нь засдаг өл буурал” гэж сүүг хэлсэн бол хоол ундны амт чанарыг засдаг амраг цагаан гэж давсыг хэлэхдээ түүний өнгийг тодотгож өгчээ. Тухайн оньсогын сүүлийн мөрд тос нь өөг цатгалан байдлыг бэлгэддэг учраас тарган шар гэж дүрсэлжээ.

Монголчууд цагаан идээг зуны улиралд түлхүү хэрэглэдэг байсан бол өнөөдөр хэрэглээ багасаж байгаа нь гаднын улс орны олон төрлийн хоол хүнсний соёл түлхүү орж ирж, нэр төрөл олширсон. Нүүдлийн соёл иргэншлээс суурин соёлд шилжсэн явдалтай холбоотой.

Шар идээ: Таван өнгө таван тансаг идээний дотор “шар идээ тос, тослогийн зүйлийг заах бөгөөд аливаа идээний оройд титэм болж явдаг” (Дулам, 1992: 36) хамгийн хүндэтгэлт идээ ундаа болдог бөгөөд оньсогод дүрслэхдээ,

Бор хонь

Хэвтээгээр таргална /гүзээнд тос чихэх/, (МАОТ, 1990: 166)

гэсэнд малын гүзээг хоньтой, гүзээнд тос чихэхийг мал таргалахтай адилтган амьдчилжээ.

Монголчууд бяслагийг болсон сүүний, түүхий сүүний гэж хоёр ангилдаг.

Өөгүй дөрвөлжин

Өөх шиг цагаан /бяслаг/, (ТО, боть-I, 1966: 142)

гэж оньсоголохдоо шахсан бяслаг харагдах талаасаа өө сэвгүй дөрвөлжин хэлбэртэй байдгийг дүрсэлсэн бол түүний өнгийг малын өөхтэй ижилхэн болохыг жишин адилтгажээ. Уран дүрслэлийн аргуудаас тойрууллын аргаар бүтсэн оньсого ч байна. Жишээлбэл:

Цагаагч үнээ

Цаасан нэмнээтэй /өрөм/, (ТО, боть-II, 1959: 117)

хэмээн эхний мөрд сүүг үнээтэй адилтган амьдчилаад, удаах мөрд сүүн дээр тогтсон өрмийг малыг хүйтэн сэрүүнээс хамгаалах нэмнээтэй харагдах байдлаас нь тус бүр тойруу замаар адилтгажээ. Угтаа өрөм бол “монголчуудын цагаан идээний доторх өнгө үзэмжтэй” (МИТ, 1991: 22) учраас хүндэтгэлтэй идээний зүйлд ордог. Эдгээр идээ нь хүний биед шингэц сайтай, ходоодны галын илчийг үүсгэж сэлбэдэг учир хаврын улиралд хамгийн тохиромжтой байдгийг нүүдэлчид аж амьдралынхаа туршлагаас олж мэджээ.

Хөх (ногоон) идээ: Тухайн өнгөний бэлгэдлийн эх сурвалж нь “монголчуудын гол шүтээн “Мөнх хөх тэнгэрээс” (хөх мөнх тэнгэр, хөх мөнгөн тэнгэр, хөх манхан тэнгэр)” (Дулам, 2007: 23) эхтэй бөгөөд “хөх ногооны униар”, “хөх ногооны шим” гэсэн үг хэллэг нь өнгийн тухай монголчуудын өвөрмөц үзлийг илэрхийлнэ.

“Бүх ургамал таримлын зүйл, гурил будаа, шош, шиш, амуу, боов боорцог, эрдэс давс, чихэр бурам хөх идээнд багтана (Jargalsaikhan, 2020). Монголчууд эдгээр ургамал ногооныхоо онцлог шинжийг таньж мэдсэн мэдлэгийн үр дүнгээ залуу хойч үедээ оньсогоор дамжуулан уламжлуулж иржээ. Жишээлбэл:

Наг нагийн мод

Наян нэгэн салаатай

Салаа бүр үртэй

Үр бүр өндөгтэй /тариа/, (ТО, 1966: 48)

хэмээсэн оньсогойн эхний мөрт нэг үгийг угсруулан давтсан бол хоёрдугаар шадын сүүлийн үгийг гуравдугаар шадын толгойд давтах маягаар ашигласан нь жороо үгийн бүтэцтэй төстэй болжээ.

Монголчууд арвай будааг өсөх үржих, арвижих, баяжихын бэлгэдэл болгодог учраас хурим найр, хүүхдийн угаалгын зан үйл гэх мэтэд өргөн хэрэглэдэг тухайгаа оньсоголохдоо

Наг модон дээр саг мод

Саг модон дээр сайхан шувууны үүр

Үүр болгон өндөг

Өндөг болгон идээ /арвай будаа/, (ТО, 1966:59)

гэсэн шүлгийн хэлбэр нь эхний шадын сүүлийн үгийг хоёрдугаар шадын толгойд, хоёрдугаар шадын сүүлийн үгийг гуравдугаар шадын толгойд давтах аргаар хэлжээ. Ийнхүү шүлгийн холбоцоор хоорондоо нэгдмэл утга санааг бүрдүүлсэн онцлогтой байна.

Оньсогод “нэр өгүүлэхүүний үүрэгтэй тэмдэг нэрийг өгүүлбэрийн эцэст зэрэгцүүлэн давтаж дүрслэлээ тодруулдаг” (Ганцэцэг, 2015: 98). Энэхүү онцлог шинж,

Буурал морь бурд бурд

Бурхан ширээ тард тард /анжсаар газар хагалах/, (ТО, 1989: 209)

гэх оньсогод тодорч дүрслэгджээ.

Хөх ишиг

Цагаан хөлтэй /мангир/, (ТО, 1966: 53)

гэх буюу

Үхсэн эмгэн

Цагаан тархитай /мангир/, (ТО, 1966: 53)

гэсэн хоёр оньсогойн эхнийхэд ургамлын шинж төрхийг амьтны бие эрхтнээр амьдчилан дүрсэлсэн бол хоёр дахид хүншүүлэн дүрсэлсэн онцлог ажиглагдаж байна.

Устай байтлаа худаг биш

Хорголтой байтлаа хонь биш

Бөмбөрхий байтлаа бөмбөг биш /шийгуа/, (МАОТ, 1990: 157)

гэх оньсогод худаг, хонь, мах, бөмбөг гэсэн хоорондоо ямар ч холбоогүй субъектэд “устай, хорголтой, улаантай, бөмбөрхий” гэсэн шинж тэмдгийг (үндсэн утга санааг агуулсан) хооронд нь нэг бүхэл бүтэн цогц ойлголт болгон дүрсэлжээ.

Далан есөн хувцас

Далуулаан товчгүй /байцаа/, (Далыг далуулаа, 2003: 20)

гэх буюу

Улаан тахиа

Ногоон өрөвлөгтэй /лууван/, (Далыг далуулаа, 2003: 20)

гэсэн нь аль ч улс орны хүмүүс тааж чадахуйц дүрслэлтэй байгаагаараа нийтлэг шинжтэй байна.

Аливаа юм үзэгдлийг жишин харьцуулж тодруулах, тухай бүрд нь хэрэгтэй талаас нь ялгаж, ойлгох, олж мэдсэнээ нэгтэн дүгнэх нь тухайн хувь хүний чадвар. Монголчууд өдөр тутмын ахуй амьдралдаа хэрэглэдэг зүйлээ бусад юмтай “жишин харьцуулж адил төстэй талыг олж харан зүйрлэж, эсвэл ургуулан бодно” (Нансалмаа, 2014: 93) гэдэг нь аливааг маш сайн ажиглаж мэдсэний үр дүнгийн илрэл.

Улаан идээ: “Улаан гэдэг тодотгол цай идээний хувьд аагтай амттай гэсэн утгатай бөгөөд монгол таван өнгө идээний нэгэн зүйл нь улаан идээ буюу мах шүүс болно” (Дулам, 2000: 46). Үүнд: мах, шүүс, таван цул дотор мах тэргүүтнийг хамруулдаг. Монголчууд идээ ундааны дотроос махан шүүсийг эрхэмлэн дээдэлж, зочин гийчин ирэх, баяр ёслолын зоогт өргөн хэрэглэдэг бөгөөд монгол ардын оньсогод,

Дотор газраас ирсэн

Дондог эмгэний

Толгой нь боодолтой

Хөл нь мухар /хонины бордсон ходоод/, (МАОТ, 1990: 157)

гэж хонины ходоодыг Дондог эмгэн гэж хүншүүлэн дүрслэхдээ түүний бүтцийг хошин байдлаар оньсоголжээ. Мөн түүнчлэн,

Хөөрхөн хүүхэн

Хөвөнд боолттой /Бөөр/, (Содном, 2018: 415)

гэж малын бөөрийг хөөрхөн хүүхэнтэй адилтган дүрсэлжээ.

Бас амьтны эд эрхтний үйл ажиллагааг хүний үйл ажиллагаатай холбон амьдшуулан дүрсэлсэн тохиолдол байна.

Ац модонд

Араахан бумбаа /зайдас/, (МАО-П, 1989: 82)

хэмээн зайдсыг амьдчилж дүрсэлсэн бол:

Алтан шар эмгэн

Амандаа үстэй /гургалдай, хошног/, (ТО, боть-II, 1959: 119)

гэх оньсогод малын гургалдайн бүдүүн үзүүрийн үсийг хүний сахалтай адилтгажээ. Мөн

Нэг бяруу нэмнээтэй,

Хоёр бяруу холбоотой /Бөөр, зүрх/, (Содном, 2018: 415)

гэсэн оньсогод зүрхийг нэг бяруутай, бөөрийг хоёр бяруутай тус бүр маш оновчтой амьдшуулан дүрсэлжээ.

Бас малын эд эрхтнийг амьгүй эд зүйлтэй адилтгасан оньсого байна. Жишээлбэл:

Улаан өргөө

Цагаан хаявчтай /Зүрх/, (Содном, 2018: 414)

гэсэн энэ оньсогод малын зүрхийг улаан өргөөтэй, зүрхний амсрын өөхийг гэрийн хаявчтай адилтган нууцалж, зүрхний өнгө улаан, зүрхний амсар цагаан өнгийг ил хэлсэн. Өөрөөр хэлбэл, улаан, цагаан үгээс бүрдэл болсон адилтгал оньсого болно.

Хар идээ: “Хар өнгө бол монгол утга соёлд домог зүй, бөө мөргөлийн зүүн зүгийн 44 тэнгэрийн өнгө бөгөөд гэрэл гэгээний ерөндөг, харанхуйн төлөөлөл болж буудаг. Байгалийн сүр хүчний илэрхийлэл” (Дулам, 2000: 7-8) болдог. Энэ идээнд архи, ус зэргийг хамруулдаг. Монголчууд үр хүүхэд, залуучуудад архийг дөч хүрээд дөнгөж амс, тавь хүрээд тавьж уу гэж зааж сургаж ирсэн. Тэгвэл энэ идээг монгол ардын оньсогод,

Хангайн нуруугаар давсан чогчиго

Хайр сайрыг уруудсан чогчиго

Хар нүх рүү орсон чогчиго

Хамаг амьтыг сандраасан чогчиго /Нэрмэл архи/, (МАО, 1989: 83)

гэсэнд архи бэлтгэх үйл явцыг дүрсэлжээ. Нүүдэлчдийн дунд өргөн дэлгэрсэн эрт дээр үеэс хэрэглэж ирсэн, хөлчүүрүүлэх ундааг нэрмэл архи, шимийн архи гэж нэрлэдэг билээ.

Тэгвэл усыг оньсогод хэрхэн дүрсэлснийг тодруулбал,

Хазаар ногтгүй хар морь

Хатираад зогсохгүй хар морь /Ус/, (ТО, 1959: 83)

гэж урсгал усны шинжийг хазаар ногтгүй морины явдалтай дүйцүүлэн адилтгаж, амьдчилан дүрсэлсэн байна. Монгол сэтгэлгээнд усны өнгийг хар хэмээн тодотгодог уламжлал өнөөдөр ч байсаар байна.

Дүгнэлт

Монголчууд бэлчээрийн мал аж ахуй эрхэлж ирсэн арга туршлага нь тэдний сэтгэлгээний онцлог бий болох хөрс суурь нь болж өгсөн. Ийм учраас оньсогод таван тамсаг идээ ундаагаа уран холбоогоор оньсоголох нь түгээмэл байна. Ингэхдээ таван хошуу мал, түүний эд эрхтэнтэй адилтгаж, амьдчилж дүрсэлсэн нь элбэг байгаа нь монгол хүний аж амьдрал, ахуй, соёл, ёс заншил, түүнээс улбаалсан сэтгэлгээний онцлогтой холбоотой байна.

Онсього тэргүүтэй үгийн урлаг бол Монголчуудын өдөр аж амьдралын арга ухаан мэдлэг ухаан, таван хошуу малаа таних арга ухааныг хойч үеийнхээ сэтгэлгээнд үе дамжуулан уламжлуулж, заан сургаж, ахуй амьдралд бэлтгэж ирсэн ардын арга ухааны сонгодог жишээ гэж болно.

Эдгээрийн үр дүнд монгол хүний үзэл санаа, итгэл үнэмшил, сэтгэлгээний өвөрмөц онцлог дэлхий дахины даяаршлын эрин зуунд ч өөрийн өвөрмөц байдлаа хадгалсан үнэ цэнтэй соёлын илэрхийлэл болсоор байгаа юм.

Ном зүй

А.Монгол хэлээр:

Ганцэцэг, С. (2015). *Монгол оньсогойн ангилал, туурвил зүйн онцлог*. [Gantsetseg, S. *Mongol onisogiin angilal, tuurvil züin ontslog* [Classification and creative characteristic of Mongolian riddles] [Ulaanbaatar: EDU Press. 2015.]

Балдан, Л. (2013). *Уран зохиолыг яруу тунгалгаар найруулах эрдэм*. Улаанбаатар: Admon. [Baldan, L. *Uran zokhioliig yaruu tungalgaar nairuulakh erdem* [Skill of composing literature correctly]. Ulaanbaatar: Admon Printing. 2013.]

Далыг далуулаа, Таамаг, таамнал. (2003). Далны хуудас Дугаар 24 (4), Эрхлэн бэлтгэсэн Л.Түдэв. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Tudev L. *Dalnii khuudas, Dugaar 24(4) // Taamag, taamnal* [Hypothesis and Guessing]. Ulaanbaatar: State Publishing House. 2003.]

Дулам, С. (2013). *Монгол цагаан идээний бэлгэдэл утгын тайлал*. Монгол судлал, XXXVII (392):106. [Dulam, S. *Mongol tsagaan ideenii belgedel utgiin tailal* [Symbolism and Interpretation of Mongolian Dairy product]. *Mongol studies*, 2013, XXXVII: 106.]

Дулам, С. (2000). *Монгол бэлгэдэл зүй II дэвтэр. Өнгөний бэлгэдэл зүй, Зүг чигийн бэлгэдэл зүй*. Улаанбаатар: Битпресс. [Dulam, S. *Mongol belgedel züi II devter, öngönii belgedel züi, züg chigiin belgedel züi* [Mongolian symbolism II diary, Color symbolism, Direction symbolism]. Ulaanbaatar: Bitpress LLC. 2000.]

Дулам, С. (1992). *Цагаан сарын бэлгэдэл*. [Dulam, S. *Tsagaan sariin belgedel* [The first month of the Lunar Year of symbolism] Ulaanbaatar: Publishing house named after Sukhbaatar.1992.] Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн газар

МАО. (1989). *Монгол ардын оньсого*. Ц.Өлзийхутаг эмхэтгэв. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Mongol ardiin onisogo, Ts.Ulziikhutug emkhetgeev [Mongolian folk riddle]. Ulaanbaatar: State Publishing House.1989.]

МАОТ. (1990). *Монгол ардын оньсого таавар*. Эмхэтгэж боловсруулсан

Г.Ловор, Ц.Өлзийхутаг. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [*Mongol ardiin onisogo, taavar* [Mongolian folk riddle of conjecture]. Ulaanbaatar: State Publishing House.1990.]

Нансалмаа, Н., & Долгор, С., (2014). *Танихуйн хэл шинжлэл*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Nansalmaa, N., Dolgor, S., *Tanikhuin khelshinjlal* [Cognitive linguistics]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2014.]

Сампилдэндэв, Х. (2015). *Монгол зохиол судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Sampildendev, Kh. *Mongol aman zokhiol sudlal* [Mongolian folklore studies]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2015.]

Содном, Б. (2018). *Аман зохиол*. Дөтгөөр боть. Эмхэтгэсэн Ч.Заяасүрэн, Г.Батмөнх, Улаанбаатар: Соёмбо принтинг. [Sodnom, B. *Aman zokhiol, Dötgöör boti, Emkhetgesen Ch.Zayasuren, G.Batmünkh* [Folklore]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2018.]

Б. Цахим эх сурвалж:

<http://jargalsaikhanii.blogspot.com/>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.